

# МЭРГЭЖЛИЙН НЭР ХҮНДИЙГ СУДЛАХ НЬ

Я.Отгонбаяр

Социологийн ухааны доктор (Ph.D)

## 1. Мэргэжлийн нэр хүндийн талаарх социологийн ойлголт

Мэргэжлийн нэр хүнд нь сүүлийн 100 аад жилийн турш социологич, сэтгэл судлаач сурган хүмүүжүүлэгчдийн судалгааны судлагдахуун болсоор ирсэн. Энэ нь олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд зөвхөн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт төдийгүй улам бүр өөрчлөгдөж байгаа нийгмийн бүтэц, хүмүүсийн сонголт нээлттэй болсонтой шууд холбоотой. П.Бергер, Т.Луман нар бичихдээ<sup>22</sup> ...”социологийн онолд дараах асуултыг тавих байх... хувь хүмүүсийн мэргэжилд өгч байгаа утга учрыг хэрхэн бодит байдал болгох вэ... Мэргэжлийн нэр хүнд нь онолын хувьд боловсролд зарсан зардал, боловсролынхоо ачаар өөртөө олж авсан үйл ажиллагааны түвшинтэй холбоотой яригдана. Орчин үеийн нийгэм нь хүүхэд залуучуудыг зарим талаар зөрчилтэй нөхцөл байдалруу түлхэж байна. Тухайлбал өнөөдөр европын орнууд АНУ, Оросод хамгийн өндөр орлоготой мэргэжилд өмгөөлөгч, хуульч, эмч, эдийн засагч банкны ажилтнууд орж байна. Гэтэл нийгэмд хамгийн их хүндлэгддэг, сургуулийн багш ямар ч нэр хүндгүй болсныг нийгмээс мэргэжлийн чиг баримжаанд өгч байгаа үзэл бодлоос харж болохоор байна.<sup>23</sup> Орчин үед олон нийт хамгийн орлоготой бол хамгийн нэр хүндтэй гэж үнэлээд харин энэ нь жинхэнэ утгаараа нэр хүндтэй байх албагүй юм. Хүндлэлтэй мэргэжлүүд нь эсрэгээр хамгийн ашиггүйд тооцогдож байна. Уламжлалт нийгэмд мэргэжлийн нэр хүндийг зөвхөн ганц орлогоор тооцдоггүй бусад олон хүчин зүйлтэй холбодог байсан.

Мэргэжлийн нэр хүндийн талаар Францын социологич Э.Дюркхайм дараах байдлаар авч үзсэн. Тэрээр аж үйлдвэржилтийн эхэн үеэс хөдөлмөрийн хуваарь гарч ирсэнтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагааны ялгарал бий болж нийгмийн зүгээс мэргэжлийг үнэлэх болсон. Үүнтэй холбоотой нийгмийн давхарга, шатлалд хүмүүс мэргэжлийнхээ нэр хүндийн дагуу харилцан адилгүй байр суурь эзэлдэг гэсэн санааг илүүтэй авч үзсэн нь түүний онцлог.

Нэр хүнд гэдэг ойлголт нь хэл зүйн хувьд латин хэлний *praestigiūm*-хий хоосон, сэтгэл татах франц хэлний *prestige*- сэтгэл татах, герман хэлний нөлөө хүндлэл<sup>24</sup> гэсэн үгнээс гаралтай Социологид нэр хүнд хэмээх ойлголтын дор нийгэм болон нийгмийн бүлгээс аливаа үзэгдэл нийгмийн байдалд өгч байгаа ач холбогдол, тодорхойлолтыг ойлгодог.<sup>25</sup>Тийм учраас нэр хүнд нь практик утгаараа алдар хүнд хэмээх ойлголт түүний нийгэмд хэрхэн тайлбарлагдаж байгаа хоёрын тэнцүү байх явдал юм. Девид Джуле Джери нар нэр хүнд хэмээх ойлголтыг эерэг ба сөрөг үнэлгээг давхар агуулна гэж үзсэн. Тэдний үзлээр энэ ойлголт нь ихэвчлэн статустай ойролцоо утгатай юм шиг ашиглагддаг.

Нэр хүнд хэмээх ойлголтыг судлахад тухайн мэргэжлийн нийгмийн нэр хүнд, мэргэжлийн нэр хүнд гэдгийг ялгах хэрэгтэй. Т.Парсонс өөрийнхөө онолд нэр хүндтэй байх гэсэн ойлголтыг авч үзжээ. Энэ нь бүхэлдээ тухайн мэргэжлийн үйл ажиллагаанд шаардагдах мэргэжил боловсролын нэгдэл. Тухайн мэргэжлийн нэр хүндийг хангах мэргэжлийн бэлтгэл хэр хангагдсаныг сертификат тодорхойлдог учраас нэр хүнд гэдэг ойлголт формаль боловсролд ч хамаарна. Мэргэжилд хандах Т.Парсонсын социологийн хандлагын онцлог нь тухайн мэргэжлийн нэр хүнд гэдэг бол нийгмээс үнэлэгдэх, түүний нэр хүндийг олж авах баталгаатай байх ёстой. Өнөөдөр дэлхийн судалгааны практикт ялангуяа Америкийн Чикагогийн социологийн чиглэлд мэргэжил гэсэн ойлголтын дор зөвхөн уламжлалт төдийгүй орчин үед өргөн тархаж байгаа уламжлалт бус шинэ мэргэжлүүдийг ч хамруулан ойлгож байна. Америк, Английн социологи мэргэжлийг судлах өөрийн гэсэн уламжлалтай. Социологи дахь позитивистууд дараах загвараар мэргэжлийн төгс шинжийг тодорхойлсон<sup>26</sup>. Үүнд:

<sup>22</sup>Ред. Певная М.В и др. Профессиональный имидж и престиж социальной работы. Монография Екатеринбург .2011.,стр-15

<sup>23</sup>Бергер,П, Луман Т.Трактат по социологии знания. М.,1996. стр-19

<sup>24</sup>Под. ред. Ребера А. Оксфордский толковый словарь по психологии М.2002

<sup>25</sup>Голованов. О Краткий словарь по социологии М.,2001

<sup>26</sup>Мансуров В.А Профессиональные группы интелгенций М.2003 стр-66

1. Практик чадвар нь хийсвэр мэдлэг дээр үндэслэх. Өөрөөр хэлбэл мэргэжлийн суурь бэлтгэл системлэг байх.
2. Мэргэжлийн практик нь зан үйл, хэм хэмжээ, үнэт зүйл, мэргэжлийн соёл зэрэг урт хугацааны бэлтгэл шаарддаг.
3. Мэргэжлийн нэр хүнд нь нийгмийн үндсэн үнэт зүйлтэй тохирох.
4. Мэргэжил нь нийгэмд үйлчлэхэд чиглэгдсэн байх.
5. Мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг сахих

Германы сонгодог социологич М.Вебер мэргэжлийг тайлбарлахдаа мэргэжлийн групп хэмээх ойлголтонд илүү их ач холбогдол өгсөн. Тухайлбал нийгэмд тодорхой байр суурь эзлэх, эдийн засаг, засаглал, соёлын үнэт зүйлийг эзэмшихэд ямар мэргэжлийн бүлэгт хамаарч байгаагаас нь шалтгаална гэж үзсэн. Социологийн түүхэнд мэргэжлийн нэр хүнд хэмээх ойлголтыг нийгмийн давхраажилтын онолын хүрээнд нийгмийн тодорхой бүлэг, давхраанд эзлэх байр суурийг тодорхойлогч хүчин зүйл гэж тайлбарладаг. М.Веберийнхээр социаль статус нь амьдралын хэв маяг, боловсрол, мэргэжлийн нэр хүнд гэсэн хүчин зүйлээр тодорхойлогддог. Орчин үеийн социологийн онолд мэргэжлийн нэр хүнд нь шинжлэх ухааны ойлголтын хувьд хангалттай боловсруулагдсан бөгөөд нийгмийн үнэт зүйл хэм хэмжээний системд хэрхэн үнэлэгдэх төдийгүй янз бүрийн шинжтэй хөдөлмөрийн үйл ажиллагааг хүмүүсийн үнэлэх субъектив үнэлэмж, мөн боловсролын түвшин, үүрэг хариуцлагыг ч давхар тооцож байна. Гэтэл орчин үед мэргэжлийн нэр хүндийн тухай ярихдаа мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай боловсролын түвшин, цалингийн хэмжээ, нийгэмд давамгайлах үнэт зүйл, хэм хэмжээнд нийцэж байх зэрэг нийгэм-соёлын олон шинжээр тайлбарлаж байна.

XX зууны эхэн үеэс Америкт янз бүрийн мэргэжлийн нэр хүндийг судлах эмпирик судалгаанууд хийгдэж эхэлсэн бөгөөд ялангуяа нийгмийн янз бүрийн бүлгүүдийн төлөөлөл мэргэжлийн нэр хүндийн талаар ямар төсөөлөлтэй байгааг тодорхойлсон. Үүнтэй холбоотой Д.Трейман мэргэжлийн нэр хүндийн талаар өөрийн онолоо боловсруулахдаа янз бүрийн асуулгаар 60 гаруй улс орны мэргэжлийг судалж нэр хүндийн хоорондын хамаарлыг тооцоолон стандарт шкалыг боловсруулсан.

Дж.Каунте social standing<sup>27</sup> гэсэн ойлголтыг социологийн талаас боловсруулахдаа мэргэжлийн нэр хүнд мөн нэр хүндийг илэрхийлэх байдал, нийгмийн тодорхой шатлалд эзлэх мэргэжлийн байр суурь, бүх нийгэм дэх нэр хүндийн түвшинтэй яг адил гэж үзжээ. Тэрээр мэргэжлийн нэр хүндийн асуудлыг харьцангуй практик талаас нь судалгааны үндсэн дээр боловсруулсан. 1925 онд өөрийн судалгаандаа сургуулийн сурагчдыг мэргэжлийн байр суурийн талаар хуурмаг төсөөлөл, буруу ойлголттой байснаас өөрт тохирох мэргэжлийг сонгож чадахгүй байна гэсэн таамаглал дэвшүүлж Америкийн янз бүрийн мужийн сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд судалгаа хийж 45 мэргэжлийг санал болгож тус бүрийнх нь онцлог, байр суурийг үнэлүүлсэн. Энэ судалгааныхаа үндсэн дээр нэлээд удаан хугацаанд олон нийтийн санал асуулга явуулж янз бүрийн мэргэжлийн нэр хүндийг хэмжих төгс шкал боловсруулах арга зүйг бий болгохыг эрмэлзсэн. XX зууны хоёрдугаар хагаст Америкийн социологид судалгаанд оролцогчдын орлого, боловсролын түвшинг судалснаар мэргэжлийн нэр хүндийг хэмжих нийгэм эдийн засгийн индексийг тооцох оролдлого хийж эхэлсэн.

О.Данкен анх 500 төрлийн ажил мэргэжлийн нийгэм эдийн засгийн индексийг тодорхойлсон. Нийгэм-эдийн засгийн индекс нь мэргэжлийн нэр хүндийг тодорхойлоход хамгийн түгээмэл тохиолдох хэмжүүр байсан.<sup>28</sup> XX зууны сүүлээр мэргэжлийн нэр хүндийн өсөлтийг мэргэжлүүдийн өөр хоорондоо ялгарах онцлог шинжтэй холбож тайлбарлах алхмууд хийгдэж эхэлсэн. Тухайлбал америкийн социологич Х.Жоу мэргэжлүүдийн нэр хүндийн ялгаатай байдалд нөлөөлж байгаа хэд хэдэн хүчин зүйл, үндсэн хандлагыг гаргасан. Үүнд:

1. Мэргэжлийн нэр хүнд өндөр байх үндсэн шалтгаан нь мэргэжлийн шинжлэх ухааны мэдлэгийн ач холбогдол

<sup>27</sup>Руднев М.Г. Методология и основные результаты исследования престижа профессий в зарубежной социологии \Вопросы образования М.2008 №2 стр.-217-239\

<sup>28</sup> Мөн тэнд. х-169

2. Нийгмийн зөрчлийг хэдий чинээ бий болгоно тэр хэмжээгээр нэр хүнд нь доогуур байна.
3. Нэр хүнд нь мэргэжлийн ур чадвартай шууд хамааралтай
4. Мэргэжилд хэдий чинээ боломж их байна тэр хэмжээгээр нэр хүнд нь өндөр байна

Онолын болон эмпирик судалгааны үр дүнд мэргэжлийн нэр хүнд нь нэг талаас нийгэм, соёл, эдийн засгийн өөрчлөлт, нийгэмд ноёлох үнэт зүйл, хүн амын амьдралын түвшин, төрийн бодлого зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд нөгөө талаас мэргэжлүүдийн нэр хүндийн ялгаа нь тухайн мэргэжлийн бүлгийн гишүүдийн идэвх, мэргэжилдээ дуртай байдал, бусад нийгмийн институттэй харилцах харилцаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Мэргэжлийн нэр хүндийн үзүүлэлт нь нийгмийн субъектүүд хэрхэн үнэлж байгаагаар тодорхойлогддог.

**2. Өрнөдийн орнууд дахь мэргэжлийн нэр хүндийг судалсан эмпирик судалгааны тойм**  
Мэргэжлийн нэр хүндийг судалсан социологийн эмпирик судалгааг хэд хэдэн үе шатанд хуваан авч үзэж болно.

№	Судлаачийн нэр, улс	Судалгаа хийсэн он	Судалгааны гол онцлог
1	Джорж Каунтс АНУ-ын судлаач	1925	Ахлах сургуулийн сурагчдын дунд тодорхой мэргэжлүүдийг үнэлүүлэн мэргэжлийн нэр хүндийг тодорхойлсон.
2	Диг Патерсон АНУ-ын судлаач	1932-1934	25 мэргэжлийг жагсааж тодорхой балл өгч үнэлүүлсэн.
3	Леман Уитти АНУ-ын судлаач	1931	38878 респондентын дунд судалгаа хийж эмч, банкны ажилтан, гэгээнтэн, нисгэгч, хуульч, багш мэргэжлүүд хамгийн нэр хүндтэй байгааг харуулсан.
4	Норта Хатта АНУ-ын судлаач	1947	АНУ-ын ОНСБ-ыг судлах үндэсний төвөөс 2920 респондентын дунд судалгаа хийж 100 оноогоор мэргэжлүүдийг дүгнүүлсэн.
5	Дональд Трейман АНУ-ын судлаач	1976	Мэргэжлийн нэр хүндийг судлахдаа Пирсоны коэффициентийг ашигласан. Мөн олон улсын хөдөлмөрийн байгууллагад мэргэжлийг ангилах ISCO-68стандартыг боловсруулж өгсөн.
6	Гойдер \Канад\	1989	Мэргэжлүүдийг тодорхой шинжүүдээр нь ангилан 26 бүлэг болгоод 9 баллаар үнэлүүлсэн.
7	Ку И Сеок \БНСУ\	1990 2000 2005	15 жил тогтвортой судалсны дүнд дараах 8 мэргэжил өөрийн нэр хүндээ тогтмол хадгалж байсныг харуулсан. Тухайлбал: шүүгч, профессор, армийн генерал, худалдааны ажилтан, компанийн удирдлага, сонины сэтгүүлч, эмч, бага ангийн багш
8	Джонс Бруммон \Австрали\	2001	Мэргэжлийн нэр хүндийг тодорхойлох нийгэм-эдийн засгийн ANU-4гэсэн индексийг гаргасан.
9	В.Ф.Черноволенко \ОХУ\ В.Н.Шубкина Д.Л.Константиновский	1979 1990 2001	1970 аад оноос хойш мэргэжлийн нэр хүндийг тодорхойлох 200 гаруй судалгаа хийгдсэн бөгөөд сүүлийн жилүүдэд мэргэжлийн нэр хүндийг олон нийт үнэлэхэд ихээхэн өөрчлөлт орж байгааг харуулсан. ОХУ-д хуульч, санхүүч, бизнесмен, худалдааны ажилтан, эмч, программист зэрэг мэргэжлүүд нэр хүндтэй байгаа гэж тодорхойлсон.

Мэргэжлийн нэр хүндийг өрнөдөд Джорж Каунтс, Диг Патерсон, Леман Уитти, Норта Хатта, Дональд Трейман, Гойдер, Оросод В.Ф.Черноволенко, В.Н.Шубкина Д.Л.Константиновский зэрэг

олон судлаачид судалжээ. Тэд өөр өөрсдийн судалгаанд мэргэжлүүдийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал, арга зүйг боловсруулсан бөгөөд өөрсдийн судалгаагаараа ямар мэргэжил ямар цаг хугацаанд хэр зэрэг нэр хүндтэй байсан, энэ нь нийгмийн ямар хүчин зүйлээс шалтгаалж өөрчлөгдөж байсныг харуулахыг зорьсон. Эдгээр судлаачдийн судалгаа хийсэн цаг хугацаа, онцлогийг нь хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

### **Дүгнэлтийн оронд**

Мэргэжлийн нэр хүндийн асуудал нь социологичдийн анхаарлыг эртнээс татаж байсан бөгөөд улс болгонд янз бүрийн аргачлалын дагуу олон судалгаанууд хийгджээ.

Мэргэжил бол хүн төрөлхтний чухал үнэт зүйл юм. Орчин үед нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн түвшин нь янз бүрийн мэргэжил шинээр үүсэн гарах нөхцөлийг бий болгосоор байна.

Дэлхийд өнөөдөр хэдэн мянган янз бүрийн мэргэжил, хөдөлмөрийн байр байгаа бөгөөд өдөр тутам шинэ шинэ мэргэжил ч бий болсоор байна. Хүн төрөлхтний хөгжил дэвшлийн үр дүнд бий болсон мэргэжлүүд нь зорилго, мөн чанар, хөдөлмөрийн үйл ажиллагааны хэлбэр, үр дүн зэргээрээ өөр хоорондоо ялгагддаг. Мөн эзэмших мэдлэг, чадвар, дадал нь мэргэжил бүрийн онцлогоос хамаарч янз бүрийн агуулгатай байдаг учраас нийгэм, олон нийтийн зүгээс мэргэжлүүдийг үнэлэх, тэднийг харилцан адилгүй байр эзлүүлдэг.

Манай улсын хувьд мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг төдийлөн анхааран үздэггүй бөгөөд хүмүүсийн хамгийн их сонгоод байгаа мэргэжлийг л сонгох нь зөв, тэр хамгийн нэр хүндтэй юм байна гэсэн таамаг төдий ойлголт хүчтэй байдаг нь тийм ч оновчтой бус юм. Ялангуяа боловсролын социологийн үүднээс мэргэжил сонголт, түүний нэр хүнд, үнэлэмж, байр суурийн асуудлыг анхааран судлах нь чухал байна.

### **Ном зүй**

1. Ред: М.В.Певная и др. Профессиональный имидж и престиж социальной работы. Монография Екатеринбург .,2011
2. О.Голованов Краткий словарь по социологии М.,2001
3. В.А.Мансуров Профессиональные группы интелгенций М.,2003
4. Вопросы образования М.,2008